

Sarnafil® S 327 L

Дээврийн ус тусгаарлагч Полимер Мембран

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sarnafil® S 327 L нь полиэфирээр хүчитгэсэн, олон үет дээврийн синтетик ус тусгаарлагч бөгөөд дээд зэргийн Поливинилхлоридод (PVC) суурилсан бүтээгдэхүүн юм.

Sarnafil® S 327 L мембраны хамгийн дээд давхрагыг өвөрмөц лакан түрхлэгээр бүрсэн бөгөөд энэ нь мембраныг агаарын бохирдол, зэврэлт, өнгөө алдахаас хамгаалдаг.

Хэрэглээ

Механикаар бэхэлсэн, хавтгай дээвэрүүдэд

Шинж чанар / Давуу Талууд

- Элэгдэл болон Хэт ягаан туяаны (UV)-ны өндөр хамгаалалттай
- Гагнагдах чанар маш өндөр
- Хүйтэн орчинд уян хатан чанараа хадгалах чадвар маш өндөр
- Хэмжээсийн тогтвортой байдал маш сайн
- Суналтын болон тасралтын бат бэх маш өндөр
- Механик нөлөөг тэсвэрлэх чадвар маш өндөр
- Усны ууршилтыг нэвчүүлэх чадвар сайтай
- Нарны тусгалыг ойлгох чадвар сайтай (цагаан өнгөтэй мембраны хувьд)
- Олон төрлийн өнгөний сонголттой
- Лакан түрхлэгээр хамгаалагдсан тул бохирдлын тогтоц багатай
- Хог хаягдлыг дахин ашигладаг

Хэлбэр

Харагдах байдал / Өнгө

Дээд давхрага:
Доод давхрага:

Цагаан (бусад өнгийг захиалгаар)
Хар саарал

Савлагаа

Стандарт Sarnafil® S 327 L нь 2,0 м-ийн өргөнтэйгээр тус тусдаа цэнхэр өнгийн PE-хучлагаар ороосон байдаг бөгөөд өргөний хувьд дараах сонголтуудтай:

1,2 мм	25,0 м	(ороомог нь ойролцоогоор 82 кг)
1,5 мм	20,0 м	(ороомог нь ойролцоогоор 78 кг)
2,0 мм	15,0 м	(ороомог нь ойролцоогоор 81 кг)

Хадгалалт

Хадгалах нөхцөл /
Хадгалах хугацаа

Ороомогийг нарны шууд тусгал, бороо, цаснаас хамгаалж, подоон дээр хөндлөнгөөр нь байршуулж хадгална. Зөв хадгалсан тохиолдолд хадгалалтын хугацаа дуусахгүй.

Тээвэрлэлт болон хадгалалтын явцад подоон дээрх ороомгийг бүү овоолоорой.

Construction

Техникийн үзүүлэлт

	Нэгж	Тестийн аргачлал	Шинж чанар		
			S 327-12 L	S 327-15 L	S 327-20 L
Үр ашигтай зузаан	мм	EN 1948-2	1.2	1.5	2.0
Усанд тэсвэртэй байдал	-	EN 1928	Тэнцсэн	Тэнцсэн	Тэнцсэн
Шингэн бодисд нөлөөлөх нөлөөлөх (усыг оролцуулан)	-	EN 1847	Хүсэлтийн дагуу гаргах өгөх боломжтой		
Гадна галын үзүүлэлт		EN 1187 EN 13501-5	B _{ROOF} (t1)< 20°	B _{ROOF} (t1)< 20°	B _{ROOF} (t1)< 20°
Галд үзүүлэх нөлөө	-	EN ISO 11925-2 EN 13501-1	E	E	E
Мөндөр тэсвэрлэх чадвар					
Хатуу гадаргуу дээр	м/с	EN 13583	≥ 17	≥ 20	≥ 28
Уян гадаргуу дээр	м/с		≥ 25	≥ 28	≥ 36
Усны уурыг нэвтрүүлэх чадвар	-	EN 1931	15,000	15,000	15,000
Залгаасын хуулрах (Joint peel) эсэргүүцэл	N/50 мм	EN 12316-2	≥ 300	≥ 300	≥ 300
Залгаасын шилжих (joint shear) эсэргүүцэл	N/50 мм	EN 12317-2	≥ 800	≥ 800	≥ 800
Суналтын бат бэх	N/50 мм	EN 12311-2	≥ 1000	≥ 1000	≥ 1000
Суналт	%	EN 12311-2	≥ 12	≥ 12	≥ 12
Цохилтонд тэсвэрлэх чадвар					
Хатуу гадаргуу дээр	мм	EN 12691	≥ 450	≥ 600	≥ 900
Зөөлөн гадаргуу дээр	мм		≥ 800	≥ 900	≥ 1250
Хөдөлгөөнгүй ачааллыг тэсвэрлэх чадвар					
Хатуу гадаргуу дээр	кг	EN 12730	≥ 20	≥ 20	≥ 20
Зөөлөн гадаргуу дээр	кг		≥ 20	≥ 20	≥ 20
Тасралтын бат бэх	N	EN 12310-2	≥ 200	≥ 200	≥ 200
Хэмжээсийн тогтвортой байдал	%	EN 1107-2	≤ 0.4	≤ 0.4	≤ 0.4
Хүйтэн орчинд нугалах чадвар	°C	EN 495-5	≤-25	≤-25	≤-25
Хэт ягаан туяаны нөлөөлөл	-	EN 1297	Тэнцсэн (5000 ц)	Тэнцсэн (5000 ц)	Тэнцсэн (5000 ц)
Нарны тусгалын ойлтын индекс			ASTM E 1980-01		
Цагаан өнгөтэй мембран	104				

Системийн мэдээлэл

Системийн бүтэц

Дан давхрага бүхий дээврийн системд хэрэглэгдэх тестлэгдэж, зөвшөөрөгдсөн Sika-ийн олон төрлийн нэмэлт бүтээгдэхүүнүүд байдаг. Жишээ нь: ууршилт удаашруулагч, дулаалгын шийдлүүд, хамгаалалтын давхрага, боолтууд, булан тохой г.м нарийн ажиллагаанд ашиглагдах мембранууд, цавуу, даруулга төмрүүд, мөн булан төмөр, хаялганы хоолойнууд, явган гарц, аянга зайлуулагчийн хавчаар г.м зориулалтын эд ангиудыг үйлдвэрлэдэг.

Гүйцэтгэлийн мэдээлэл

Гадаргуун чанар

Гадаргуу нь нэгэн жигд, тэгш байхаас гадна тос тосоол, тоос шорооноос ангид цэвэр байх шаардлагатай.

**Гүйцэтгэлийн нөхцөл /
Хязгаарлалтууд**

Sarnafil® S 327 L мембраныг газарзүйн хувьд сарын дундаж температурын үзүүлэлт -30°C-аас +50°C хэмийн орчинд хэрэглэх боломжтой.

Зохицол

Sarnafil® S 327 L нь EPS, XPS, PUR, PIR болон PF г.м бусад төрлийн хуванцар материалтай бүрэн зохицдоггүй. Sarnafil® S 327 L нь давирхай, битум, тос болон шингэлэгч агуулсан материалуудад тэсвэртэй биш. Тиймээс батлагдсан хамгаалалтын давхрага хэрэглэж, зохимжгүй гадаргуугаас Sarnafil® S 327 L-г бүрэн усгаарлах шаардлагатай.

Гүйцэтгэлийн зааварчилгаа

**Гүйцэтгэлийн аргачлал /
Багаж**

Sika-ийн дан давхрагад PVC мембраны Гүйцэтгэлийн Гарын авлагатай танилцана уу.

Sarnafil® S 327 L нь зөв өнцгөөр дээврийн чиглэл дагуу суурилуулах бөгөөд мембраны залгаасыг хооронд нь 120 мм давуулан наах ёстой. Мөн Sika-ийн зөвшөөрөгдсөн боолтоор мембраны ирмэгээс 30 мм-ийн зайтай дээврийн гадаргуу дээр бэхэлж өгнө. Боолтуудын хоорондын зайг тухайн төслийн Техникийн Шаардлага дээр үндэслэн Sika тооцоолж өгөх болно.

Мембраныг хооронд нь давуулан наахдаа халуун агаараар гагнах цахилгаан багаж болон даралтад өнхрүүш ашиглах буюу эсвэл автомат халуун агаараар гагнах машин ашиглана.

Санал болгож буй тоног төхөөрөмжийн төрөл: Leister Triac PID (гаг гагнуур багаж) болон Sarnamatic 661 Plus (автомат гагнуурын машин).

Гагнуурын ажлын гүйцэтгэхдээ орчны температур, гагнуурын тоног төхөөрөмжийн хүчин чадал, агаарын урсгал, даралт болон тоног төхөөрөмжийн тохиргоо г.м гагнуурын үзүүлэлтүүдийг талбай дээр сайтар хянаж, шалгаж байх шаардлагатай. Мембраныг хооронд нь давуулан халуун агаараар гагнах хамгийн үр дүнтэй өргөн нь хамгийн багадаа 20 мм байна.

Гагнасан хэсгийн чанарыг өтвөрткийн тусламжтайгаар шалгаж үзнэ. Дутуу гагнагдсан гологдолтой хэсгийг халуун агаарын гагнуураараа засварлана.

**Гүйцэтгэлийн үеийн
Анхаарах зүйлс /
Хязгаарлалтууд**

Гүйцэтгэлийг зөвхөн Sika-ийн зөвлөсөн, зөвшөөрөгдсөн дээврийн гүйцэтгэгчээр хийлгэх шаардлагатай.

Мембраны гүйцэтгэлийн үеийн температурын хязгаарлалтууд:
Гадаргуун темп: хамгийн багадаа -30°C / хамгийн ихдээ +60°C
Орчны темп: хамгийн багадаа -20°C / хамгийн ихдээ +60°C

Цавуу, цэвэрлэгч г.м зарим нэр төрлийн нэмэлт бүтээгдэхүүнийг +5°C хэмээс дээш орчинд гүйцэтгэлийг хийх шаардлагатай. Тухайн бүтээгдэхүүний Техникийн Үзүүлэлттэй сайтар танилцана уу.

Тухай орон нутгийн аюулгүй ажиллагааны дүрэм журамд тусгагдсан тохиолдолд +5°C хэмээс доош хэмд гүйцэтгэлийг хийхдээ тусгай арга хэмжээг хангаж ажиллах шаардлагатай.

Дүгнэлт Энэхүү Техникийн зааварчилгаанд лабораторийн туршилтын үндсэн дээр батлагдсан техникийн үзүүлэлтүүд тусгагдсан ба бодит үзүүлэлтүүд нь тухайн нөхцөл байдалд өөр өөр байж болно гэдгийг анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

Эрүүл мэнд, Аюулгүй Ажиллагааны мэдээлэл Бүтээгдэхүүнийг зөв хэрэглэх, хадгалах, химийн бодисын хаягдлыг зайлуулах зэрэг Аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мөн физик, экологи, хортой байдал болон бусад аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг цогцоор агуулсан Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудаснаас авах бүрэн боломжтой.

Хууль эрх зүйн мэдээлэл Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika (Thailand) Limited
Head Office
700/37 Moo 5 Bangpakong Industrial Park II,
Km.57 Bangna-Trad Rd., T.Klongtamhru,
Muang District, Cholburi 20000

Tel: +66 3821 4270-85
Fax: +66 3821 4286
E-mail: sikathai@th.sika.com
website: <http://www.sika.co.th>

